



МОНГОЛ УЛС
ХЭНТИЙ АЙМГИЙН ЗАСАГ ДАРГЫН
ЗАХИРАМЖ

2019 оны 01 сарын 11 өдөр

Дугаар А/15

Хэрлэн сум

Газар эзэмшүүлэх тухай

Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.3, 30 дугаар зүйлийн 30 1.5 дахь заалт, Захиргааны ерөнхий хуулийн 49 дүгээр зүйлийн 49.3.1, Тазрын тухай хууль"-ийн 21 дүгээр зүйлийн 21.3.2 дахь заалтыг тус тус үндэслэн ЗАХИРАМЖЛАХ нь:

1. "Газрын кадастрын мэдээллийн сан"-г солбицлын нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх ажлын хүрээнд "Газрын кадастрын мэдээллийн сангийн өгөгдлийг засварлах, геодезийн солбицол, өндөр тусгагийн нэгдсэн тогтолцоонд шилжүүлэх, турших, нэгж талбарын хувийн хэргийг шинэчлэн бүрдүүлэх" ажил хэрэгжсэнтэй холбогдуулан "Кинза трейд" ХХК-д 19060 м² газрыг эзэмшүүлсүгэй.

2. "Кинза трейд" ХХК-ий газрын кадастрын зураглалыг хавсралтаар баталсугай.

3. Газар эзэмших эрхийн гэрчилгээг олгон гэрээ байгуулж, гэрээний биелэлтэд байнгын хяналт тавьж ажиллахыг Газрын харилцаа, барилга, хот байгуулалтын газар /Д.Баярхүү/-т үүрэг болгосугай.

4. Газар эзэмших гэрээнд тусгагдсан зориулалт, нөхцөлийн дагуу газраа эзэмшин, гэрээний биелэлтийг жил бүр дүгнүүлж байхыг "Кинза трейд" ХХК-ий захирал /Ц.Алтанхүү-д/ үүрэг болгосугай.

5. Энэхүү захирамжийг гаргасантай холбогдуулан аймгийн Засаг даргын 2003 оны 211 дүгээр захирамжийн хавсралтын 5 дахь хэсгийг хүчингүй болгосугай.

ЗАСАГ ДАРГА



Н.ГАНБЯМБА

Хэнтий аймгийн Газрын Харилцаа Барилга Хот Байгуулалтын Газар

Аймгийн Засаг даргын 2019 оны
01 сарын 11 өдрийн 11/3 тоот
захирамжийн хавсралт

Нэгж талбарын дугаар: 2311034504

Хуулийн этгээдийн нэр: Кинза трейд ХХК Алтанхүү

Ашиглалтын төрөл: эзэмших

Регистрийн дугаар: 2644592

ХАЯГ: Аймаг/Хот: Хэнтий

Сум/Дүүрэг: Хэрлэн

Баг/Хороо: 3-р баг, Баянмөнх

Кадастрын муж: 110

Гудамж: Тэмүүжин

тоот: С-18

Орчны тойм:

Орчны тойм:

Координатын систем:
WGS84 / UTM 49N
EPSG: 32649



Масштаб = 1:25000



Талбайн хэмжээ: 19060 квадрат метр

Зураг хэвлэсэн: Н.Болор-Эрдэнэ
(Кадастрын мэргэжилтэн)

Хянасан: Дарга
(Д.Баярхүү)

Зургийн масштаб = 1:2500 (1 сантиметрт 25 метр багтана)

Хэвлэсэн огноо: 2019-01-03